

ТАНИЛЦУУЛГА

Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай
хуулийн төслийн талаар

Эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд бид хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр “Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулгыг боловсрууллаа.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван Зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт “...өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх....” эрхийг баталгаатай эдлэхээр заасан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ийн баримт бичгийн 2.4.1.13-т “төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж санхүүжилт олгох замаар үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангах”, 2.4.8.6-д эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад ... төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх.” зорилтыг Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдлын чиглэлээр дэвшүүлснийг үндэслэн боловсруулсан болно.

Хуулийн төсөлд эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдал, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэргэжлийн нэр хүнд, ёс зүй, хариуцлага, нийгэм-эрх зүйн хамгаалалтыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн нэгдсэн, өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгалаа.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын хөл хорионы нөхцөл байдалтай уялдуулан Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгуулсан ба тус хэлэлцүүлэгт 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн ихэнх төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, сумын болон өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцлоо. Хэлэлцүүлгийн үеэр эмнэлгийн мэргэжилтэн, багш, эрдэмтэн судлаачдаас гаргасан саналыг нарийвчлан судалж, хуулийн төсөлд тусгалаа.

Мөн “Монголын мэс засалч эмч нарын чуулган-2020” Орхон аймагт зохион байгуулагдсан ба тус үйл ажиллагаанд Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай илтгэл тавьж, хэлэлцүүлж, хэлэлцүүлэгт оролцсон 270 орчим эмч нар дэмжсэн гарын үсгээ зурж өгсөн болно.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт, хуулийн нийтлэг үндэслэл болох хуулийн зорилтыг тодорхойлж, эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлыг

зохицуулах хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн болон ёс зүйн зарчмыг тусгалаа.

Эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага, мэргэжлийн болон мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчмыг тодорхойлов.

Хоёрдугаар бүлэгт, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт, түүнийг зохион байгуулах, шалгалтын даалгавар, журам, гэрчилгээ олгох, хүчингүй болгох санал хүргүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг тусгалаа.

Тухайлбал эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шалгалтыг сорилын болон тохиолдолд сууриссан гардан үйлдлийн хэлбэрээр шалгалтын комисс зохион байгуулж авах бөгөөд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд анхаарсан. Учир нь одоо мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг зохион байгуулж буй Эрүүл мэндийн хөгжлийн төв нь хүний нөөц, санхүүжилтийн хувьд гардан үйлдлийн шалгалтыг авах боломж бүрдээгүй юм.

Гуравдугаар бүлэгт, хүний их эмч болон сувилагчийн тангараг, түүнийг өргөх ёслолын журам, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг, хориглох зүйл, хариуцлагыг тусгалаа.

Хүний их эмчийн тангараг нь Гиппократын тангарагаас эхтэй бөгөөд ёс зүйн хувьд төлөвшүүлэх, ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллах үүргийг хүлээлгэдэг юм.

Дөрөвдүгээр бүлэгт, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн хамгааллыг дэмжих, эрх зүйн хамгаалалтыг тусгалаа.

Эмнэлгийн мэргэжилтний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж, нэр төр, алдар хүндэд нь халдах, бие махбодод халдаж зодох, аливаа хүчирхийлэл, заналхийлэлд өртсөн тохиолдолд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэхээр тусгасан. Мөн эмнэлгийн мэргэжилтнүүдийн асуудлаар холбогдох байгууллагатай хамтран дэмжлэг үзүүлэх, санал хүсэлт гаргах, шаардлага тавьж ажиллах үүргийг Эмнэлгийн мэргэжилтнүүдийн танхимд хүлээлгэхээр тусгасан.

Тавдугаар бүлэгт, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хараат бус, бие даасан, улс төрөөс ангид, өөрөө удирдах ёсны, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг тусгасан.

Зургадугаар бүлэгт, Улсын Их Хурал, Засгийн газар, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Эмнэлгийн мэргэжилтнүүдийн танхимтай харилцах, түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг зохицуулалтыг тусгасан болно.

---оОо---